



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 25/124

Улаанбаатар хот

Төслийн хэрэгжилтийг хангах зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.48.2 дахь хэсэг, Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалт, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.11 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.1.19, 1.2.9 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 38 дугаар тогтоолын 6 дахь заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Баянзүрх дүүргийн 11, 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийн зориулалттай "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ-ын эзэмшил газрын 40 га талбай бүхий газарт төрийн үйлчилгээний барилга байгууламж, соёлын бүтээн байгуулалтын хөгжлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг зөвшөөрч, газрын байршил, талбайн хэмжээ, хилийн заагийн солбицлыг хавсралтаар баталсугай.

2. Төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа), Ногоон хөгжлийн хороо (Б.Золтуяа)-нд тус тус даалгасугай.

ДАРГА



А.БАЯР

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 25/24  
дүгээр тогтоолын хавсралт



**ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ,  
ТАЛБAYН ХЭМЖЭЭ, ХИЛИЙН ЗААГИЙН СОЛБИЦОЛ**

Д/д	Дүүрэг	Хороо	Байршил	Талбайн хэмжээ /м.кв/	Цэгийн дугаар	Х	У
1	Баянзүрх	26	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	400000	1	649201.172	5306511.156
					2	648281.370	5306325.883
					3	648220.508	5306634.970
					4	648480.069	5306682.109
					5	648442.925	5306903.780
					6	649076.762	5306935.703
					7	649149.857	5306680.617
					8	649201.172	5306511.156
Нийт				400000		40 га	